



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/589

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 54 дүгээр “Аймгийн 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Нисэхийн зүүн талын 1 км урттай автозамын шинэчлэл ажлын тендерийн хэмнэлт 61,786,261 (жаран нэгэн сая долоон зуун наян зургаан мянга хоёр зуун жаран нэг), Дэлгэрэх голын гольдролын тохижилтын ажлын тендерийн хэмнэлт болох 3,774,358 (гурван сая долоон зуун далан дөрвөн мянга гурван зуун тавин найм) төгрөг, нийт 65,560,619 (жаран таван сая таван зуун жаран мянга зургаан зуун арван ес) төгрөгийг Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажилд зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101252